

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/81 дүгээр захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэгийг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, ажилтан, алба хаагчдын оролцоог хангаж, хуваарийн дагуу өндөр түвшинд зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.				
1.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/81 дүгээр захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэгийн хуваарьт Чингэлтэй дүүрэг ороогүй болно.			
<b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, үерийн хамгаалалтын далан сувгийн цас, мөс, лаг шаврыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.				
2.	<p>Чингэлтэй дүүргийн Онцгой комиссын даргын “Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллах тухай чиглэлийг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр холбогдох хэлтэс, хороодын Засаг дарга нарт хүргүүлсэн. Мөн Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн <a href="http://chd.nema.gov.mn/">http://chd.nema.gov.mn/</a> сайт болон пэйж хуудас, дүүргийн цахим хуудас, 1-24 дүгээр хороод тус бүрийн цахим сайт, Иргэний танхимын пэйж хуудсаар дамжуулан сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажиллалаа. Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлтэй байршлуудад 7 хоног бүр тогтмол хяналт тавин ажиллаж, дүүргийн 12 дугаар хороо Дэнжийн мянгын 1, 3 дугаар сувгийн халиа авто зам, явган зам руу халих эрсдэл үүссэн үед Геодези, усны барилга байгууламжийн газарт мэдэгдэж арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Дүүргийн 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэр үерийн далан суваг, гуу жалганд үүссэн хог хаягдлыг “Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ийн иргэдийн бүлэг хуваарийн дагуу цэвэрлэж, хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажиллаж байна. Дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-ийн харьяа иргэдийн бүлгийн 20 хүний бүрэлдэхүүнтэй гэр хорооллын далан суваг, гуу жалга дагуу цас, мөс, лаг хаягдлыг хуваарийн дагуу 7 хоног бүр тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Цэвэрлэгээний явцад 03 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт <b>15232 м2</b> талбайн <b>79,2</b> тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан ачилт хийн, цэвэрлэн ажиллалаа.</p>			90

**Үүрэг даалгавар ГУРАВ:** Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа, худалдаа, үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг орчныхоо 50м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээх, цэвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.	<p>Дүүргийн хэмжээнд 2023 оны 02 дугаар сард Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, нийт 400 аж ахуй нэгж, байгууллагуудын 450 хүн, зах худалдааны төвийн 35 ажилтан, албан хаагч хариуцаж буй орчны 50м хүртэлх талбайн цас мөсийг цэвэрлэсэн. Хаягийн байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулан угааж цэвэрлэсэн.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хариуцах орчны 50 метр хүртэлх цэвэрлэгээг эрчимжүүлэх тухай” дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг ханган дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд дараах чиглэлийг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Хариуцах орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх</li> <li>➢ Халтиргаа гулгаанаас сэргийлэх</li> <li>➢ Хаягийн байгууламжийн өнгө үзэмжийг сэргээн, чийгтэй цэвэрлэгээний ажилд 513 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.</li> </ul>			70
----	--	--	--	----

**Үүрэг даалгавар ДӨРӨВ:** Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө болон угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг айл өрхүүдэд өгч ажиллах.

4.	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/288 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн батлагдсан төлөвлөгөөний дагуу дүүргийн 7-24 дүгээр хороодын Засаг дарга нартай хамтран сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө болон угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийн гарын авлагыг 2023 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 08-ны өдрийн хороонд нийт 20,418 галлагаатай айл өрхөд “Гараас гарт” уриатайгаар хүргүүлэн ажилласан. Дүүргийн болон хороодын цахим хуудсаар дамжуулан угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг тогтмол түгээн ажиллаж байгаа ба Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК болон “Найши трейд” ХХК-уудтай хамтран угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийн аудио бичлэгийг тогтмол иргэд олон нийтэд хүргэж байна.</p>			70
----	---	--	--	----

**Үүрэг даалгавар ТАВ:** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

5.	<p>Дүүргийн цахим сайтын байнгын ажиллагааг ханган, Үндэсний дата төвд байрлах байнгын серверийг бэлдэх, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор вэб сайтыг шинэчлэн ашиглалтад оруулах ажил явагдаж байгаа ба 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Дата бааз хуулах ажил хийгдэж байна. Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл,</p>			70
----	--	--	--	----

	өдөр тутмын мэдээ, зөвлөмжийг Чингэлтэй дүүрэг /Chingeltei District/ фэйсбүүк пэйж хуудас, Chingeltei.gov.mn вэб сайтад үнэн бодит мэдээллийг шуурхай хүргэн ажиллаж байна.			
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх				
6.	2023 оны 02 дугаар сарын байдлаар: <ul style="list-style-type: none"> <li>➢ Дүүргийн төсөвт 29,101.9 сая төгрөг төвлөрөхөөс 28,541.2 сая төгрөг төвлөрч 98%-н биелэлттэй</li> <li>➢ Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 19,290.1 сая төгрөг шилжүүлэхээс 19,290.1 мянган төгрөг шилжүүлж 100%-н биелэлттэй ажилласан.</li> </ul>			90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ